

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 01

Дугаар № 03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 59 дүгээр зүйлийн 59.3, 60 дугаар зүйлийн 60.1, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 62.1.15, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дах хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дах хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 10.2, 10.7, 11.16.6, 11.16.12 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Барилга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2025 оны 08 сарын 11-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Анкарагийн гудамж, Корпорейшн тауэрын 15 давхарт байрлах Компанийн хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1.Барилга ХК-ийн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “ХХК” гэх) болгон өөрчлөн батлах;
 - 2.2.Барилга ХК-ийг ХХК болгон хэлбэрийг өөрчлөхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 2.3.Барилга ХК-ийг ХХК болгон хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой нэгж хувьцааны бодит үнэ цэнийг тогтоосон хөндлөнгийн үнэлгээний тайланг танилцуулах;
 - 2.4.Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тогтоосон тогтоолыг танилцуулах, батлах
3. Хуралд бэлтгэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай:
 1. Комиссын дарга – Ш.Ариунбат /Дэд захирал/
 2. Гишүүд Б.Ариунтуяа /Хүний нөөцийн менежер/
Э. Батсүх /Ерөнхий нягтлан бодогч/
4. Хурлын даргаар Ш.Ариунбатыг томилсугай.
5. Хурлын тооллогын комиссын даргаар Б.Ариунзулыг, гишүүнээр Б.Ариунтуяа /Хүний нөөцийн менежер/-ийг томилсугай.
6. Хурлын зарыг 2025 оны 07 сарын 04-ний өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудасаар дамжуулан нийтэд мэдээлсүгэй.
7. Хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан 2025 оны 07 сарын 07-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2025 оны 07 сарын 22-ны өдөр хурлын зарыг дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
8. Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-р, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдах тухай зарыг хавсралт №2-р , ХЭХ-аар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны загварыг Хавсралт №3-р, хурлын дэгийг Хавсралт №4-р,

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

- “Хувьцаа эзэмшигчид танилцуулах баримт бичгийн жагсаалт”-ыг Хавсралт №5-р тус тус баталсугай.
9. Хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 07 сарын 24-ний өдөр байхаар тогтоосугай.
 10. Хурлын хэлэлцэх асуудлаар гаргах хурлын шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2025 оны 07-р сарын 09-ний өдөрт багтаан бэлтгэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
 11. Хуралд биечлэн оролцох боломжгүй Хувьцаа эзэмшигчид санал бүхий саналын хуудсыг компани дээр биечлэн эсхүл “Барилга” ХК-ийн шуудангийн хаягаар, эсхүл ubhr@barilgasor.mn цахим хаягаар тус тус хүлээн авах ба санал хүлээн авах сүүлийн өдөр нь 2025 оны 08 сарын 08-ны өдрийн 17:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
 12. Хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг Компаниас гаргахыг зөвшөөрсүгэй.
 13. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжоор хангаж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг гүйцэтгэхийг хурлын комисс даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ш.ЭРДЭНЭБАТ

Б. АРИУНТУЯА